



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

“Жонон даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа  
эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5, 14.1.4, Даатгалын тухай хуулийн 13.1.2, 70.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Жонон даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Хүчингүй болсон ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээг 2013 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Жонон даатгал” ХХК /Ш.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосонтой холбогдуулан тус компанийг татан буулгах ажлыг шүүхийн журмаар шийдвэрлүүлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

001010